



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: АРА-2026/003/НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2026 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Ахлах аудитор Н.Энхчимэг Утас: 7033-3019 Цахим хаяг: Enkhchimeg@audit.gov.mn</p>
--	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн захиргааны ордон, А корпус, 2 дугаар баг,
Эрдэнэбулган сум, Архангай аймаг, 65139,
Утас/Факс: (976) 7033 3141,
Цахим шуудан: arkhangai@audit.gov.mn

2026.03.25 № 178
танай _____-ныг № _____-т

АРХАНГАЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ
СУМЫН ЗАСАГ ДАРГА
Д.ЭНХЖАРГАЛ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Өлзийт сумын сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Архангай аймгийн Өлзийт сумын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх нэгтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Хязгаарлалттай дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно. Үүнд:

- Сумын хоршоо хөгжүүлэх сангаас олгосон 6 зээлдэгчтэй холбоотой 31,110,621 төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах арга хэмжээ авч ажиллаагүй байна.
- Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 2 нэр төрлийн нийт 2,571,500 төгрөгийн орлого тасарсан, төсвийн орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлж, төсөвт бүрэн төвлөрүүлэх арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан "Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам"-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т "Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ", 11 зүйлийн 11.3-т "Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна" гэсэн заалттай нийцээгүй бөгөөд санхүүгийн тайлагналын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитын гол асуудал

Тайлант онд Төсвийн төвлөрүүлэн захирагчийн хэрэгжүүлэх орон нутгийн гүйцэтгэл засаглалын удирдлага, орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага, орон нутгийн төсөвт олгох орлогын шилжүүлэг, жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, ерөнхий боловсрол, сургуулийн өмнөх боловсрол гэсэн 8 хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2,373,144.9 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас гүйцэтгэлээр 2,112,570.31 мянган төгрөгийг зарцуулж, төлөвлөснөөс 260,574.59 мянган төгрөг зарцуулагдаагүй байна. Энэ нь ОНХС, ХХС-нд төлөвлөснөөс 160,417.5 мянган төгрөгийг зарцуулагдаагүй, төсөвт байгууллагуудын үлдэгдэл 117,845.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн, 42,571.6 мянган төгрөгийн санхүүжилт дутуу хийгдсэнтэй холбоотой байна.

Бусад асуудлын хэсэг

Өлзийт сумын Засаг дарга нь 2025 онд аймгийн Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээгээр 14 үндсэн зорилтын хүрээнд 95 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 69 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	606,559.10	702,935.52	(96,376.42)	115.89
11	Татварын орлого	503,759.10	614,993.78	(111,234.68)	122.08
12	Татварын бус орлого	102,800.00	87,941.74	14,858.26	85.55
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,373,144.90	2,112,570.29	260,574.61	89.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,891,328.10	1,790,920.99	100,407.11	94.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,851,866.70	1,777,888.69	73,978.01	96.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	853,109.00	858,458.81	(5,349.81)	100.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,513.50	105,920.86	592.64	99.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	708,908.20	666,806.25	42,101.95	94.06
2104	Хангамж, бараа материалын зардал	61,904.40	46,533.25	15,371.15	75.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,500.00	50,822.70	(3,322.70)	107.00
2107	Томилолт, зочны зардал	10,000.00	7,650.00	2,350.00	76.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,048.60	12,651.41	9,397.19	57.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,883.00	29,045.40	12,837.60	69.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,461.40	13,032.30	26,429.10	33.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,961.40	5,401.00	23,560.40	18.65
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	382,966.80	279,649.30	103,317.50	73.02
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	98,850.00	42,000.00	56,850.00	42.49
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	-	100.00

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	900,887.78	856,598.41
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	539,629.82	539,239.49
33	АВЛАГА	319,709.31	282,278.28
35	БАРАА МАТЕРИАЛ	15,868.65	9,400.64
36	НӨӨЦИЙН БАРАА	25,680	25,680
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	2,772,454.87	3,031,826.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,772,454.87	3,031,826.57
39200	Биет хөрөнгө	2,759,591.87	3,016,788.57
39300	Биет бус хөрөнгө	12,863	15,038
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН 3=1+2	3,673,342.65	3,888,424.98
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	521.4	48,644.86
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	521.4	48,644.86
	Өглөг	521.4	48,644.86
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,672,821.25	3,839,780.12
51	Засгийн газрын хувь оролцоо	3,672,821.25	3,839,780.12
512	Засгийн газрын оруулсан капитал	433,047.38	433,047.38
52100	Хуримтлагдсан үр дүн	2,517,712.01	2,684,670.88
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	722,061.86	722,061.86
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН 6=4+5	3,673,342.65	3,888,424.98

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН	5,078,540.99	2,508,768.44
11	ТАТВАРЫН ОРЛОГО	702,972.48	614,993.78

Архангай аймгийн Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

110	Орлогын албан татвар	601,053.42	564,537.3
1100	Хувь хүний орлогын албан татвар	600,865.32	601,893.47
1101	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	0	-37,538.18
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	188.1	182
113	Хөрөнгийн албан татвар	73,545.32	29,662.58
118	Бусад татвар, төлбөр, хураамж	28,373.75	20,793.9
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	784,045.94	1,893,774.66
120	Тусламжийн орлого	0	1,279,492.93
122	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,591,522.57	0
13	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	4,073,947.65	2,028,444.22
II	УРСГАЛ ЗАРДАЛ	4,073,947.65	2,028,444.22
21	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,904,146.87	2,015,411.92
210	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,342.59	858,458.81
2101	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,949.55	105,920.86
2102	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	650,344.62	666,406.25
2103	Хангамж, бараа материалын зардал	114,097.55	71,891.25
2104	Эд хогшил, урсгал засварын зардал	77,929.51	49,222.7
2106	Томилот, зочны зардал	6,038	7,650
2107	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	25,707.75	15,437.56
2108	Бараа үйлчилгээний бусад зардал	238,737.31	240,424.49
2109	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,169,800.78	13,032.3
213	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,004,593.34	480,324.22
22	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	172,767.88	313,365.35
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (VII)=(IV)-(V)	-172,767.88	-313,365.35
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(VII)	831,825.47	166,958.87

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

№	Дансны нэр, төрөл	2024 оны 12-р сарын 31	2025 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	4,381,585.5	2,116,843.69
11	ТАТВАРЫН ОРЛОГО	702,972.48	614,993.78
110	Орлогын албан татвар	601,053.42	564,537.3
1100	Хувь хүний орлогын албан татварын буцаан олголт	-39,000.00	-37,538.18
1102	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил, үйлчилгээ хувиараа эрхлэгч	188.1	182
113	Хөрөнгийн албан татвар	73,545.32	29,662.58
118	Бусад татвар, төлбөр, хураамж	28,373.75	20,793.9
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	16,050.52	14,743.4
1181	Газрын төлбөр	10,145.13	4,045.98
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	2,178.1	2,004.53
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	87,090.45	1,501,849.9
120	Нийтлэг татварын бус орлого	87,090.45	87,941.74
122	Тусламжийн орлого	0	1,279,457.93
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	0	134,450.23
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	3,591,522.57	0
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	3,858,058.93	1,795,584.72
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,858,058.93	1,795,584.72
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,688,258.15	1,782,552.42
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	701,342.59	858,458.81
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	89,949.55	105,920.86
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	650,344.62	666,806.25
2104	Хангамж, бараа материалын зардал	56,038.15	47,790.83
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	78,212	50,822.7
2107	Томилот, зочны зардал	6,038	7,650
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,802.75	16,057.56
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	77,530.5	29,045.4
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,169,800.78	13,032.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	523,526.56	321,258.97

Архангай аймгийн Өлзийт сумын Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2025 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН	330,415.32	279,649.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	330,415.32	279,649.3
	Дотоод эх үүсвэрээр	330,415.32	279,649.3
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-330,415.32	-279,649.3
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	120,500	42,000
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-120,500	-42,000
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	72,611.24	-390.33
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	467,018.58	539,629.82
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	539,629.82	539,239.49

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө /өмч
1	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,840,995.78	2,840,995.78
2	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,840,995.78	2,840,995.78
3	Тайлант үеийн үр дүн	831,825.47	831,825.47
4	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,672,821.25	3,672,821.25
5	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,672,821.25	3,672,821.25
6	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,672,821.25	3,672,821.25
7	Тайлант үеийн үр дүн	166,958.87	166,958.87
8	2025 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	3,839,780.12	3,839,780.12

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

№	Дансны нэр, төрөл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	606,559.10	702,935.52	(96,376.42)	115.89
11	Татварын орлого	503,759.10	614,993.78	(111,234.68)	122.08
12	Татварын бус орлого	102,800.00	87,941.74	14,858.26	85.55
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,373,144.90	2,112,570.29	260,574.61	89.02
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,891,328.10	1,790,920.99	100,407.11	94.69
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,851,866.70	1,777,888.69	73,978.01	96.01
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	853,109.00	858,458.81	(5,349.81)	100.63
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	106,513.50	105,920.86	592.64	99.44
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	708,908.20	666,806.25	42,101.95	94.06
2104	Хангамж, бараа материалын зардал	61,904.40	46,533.25	15,371.15	75.17
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	47,500.00	50,822.70	(3,322.70)	107.00
2107	Томилот, зочны зардал	10,000.00	7,650.00	2,350.00	76.50
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,048.60	12,651.41	9,397.19	57.38
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,883.00	29,045.40	12,837.60	69.35
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	39,461.40	13,032.30	26,429.10	33.03
2132	Бусад урсгал шилжүүлэг	28,961.40	5,401.00	23,560.40	18.65
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	382,966.80	279,649.30	103,317.50	73.02
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	98,850.00	42,000.00	56,850.00	42.49
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2.00	2.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	25.00	25.00	-	100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
1	НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	4,663.73
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,663.73
122	Тусламжийн орлого	4,663.73
1221	Хандив тусламж /дотоод/	4,663.73
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,663.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,663.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,663.73
2104	Хангамж, бараа материалын зардал	1,257.58
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,406.15

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн аудитаар илэрсэн **33,682.1** мянган төгрөгийн зөрчлийг материаллаг гэж үнэлснээс гадна сумын төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн албаны хяналтын үр дүнтэй холбоотой санхүүгийн тайланд нэгтгэгдсэн харьяа байгууллагуудын **9,844.7** мянган төгрөгийн зөрчлийн нөлөөллийг үнэлж нийт **43,526.8** мянган төгрөгийн зөрчлийг санхүүгийн тайланд нөлөөлөх материаллаг зөрчил гэж үзлээ. Энэ нь аудитын төлөвлөлтийн үе шатанд тогтоосон материаллаг байдлын дүн **35,297.2** мянган төгрөгөөс их байгаа боловч өргөн тархаагүй тул **Хязгаарлалттай** дүгнэлт өглөө.

3.1 Албан шаардлага

3.1.1 Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого 1,399.5 мянган төгрөг, улсын тэмдэгтийн хураамжийн орлого 1,172.0 мянган төгрөгөөр тасарч, орлогын төлөвлөгөөг жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.1-д “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Сумын орлогыг нэр төрлөөр нь жигд ханган биелүүлэхэд анхаарч ажиллах, орлогыг сар улирлын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах албан шаардлага хүргүүлээ.

3.1.2. Хоршоо хөгжүүлэх сангийн 11 зээлдэгчтэй холбоотой 7-15 жилийн насжилттай 31,110.6 мянган төгрөгийн чанаргүй хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдлийг барагдуулах талаар арга хэмжээ авч ажиллаагүй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Хоршоо хөгжүүлэх сангийн авлагын үлдэгдлийг барагдуулах талаар холбогдох хууль, тогтоомжид заасан арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэн санг хохиролгүй болгох албан шаардлага хүргүүлэх

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИЙН АУДИТЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мян.төг/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ХХС	1	31,110.60			1	31,110.60		
ТНТО	1	2,571.50			1	2,571.50		
Шилэн данс	1				1			
НИЙТ ДҮН	3	33,682.10	0	0	3	33,682.10	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс			
			Төлбөрийн акт		Албан шаардлага	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
Шилэн дансны хуулийн хэрэгжилт	1	-	-	-	1	-

ТӨСВИЙН ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧИД НЭГТГЭГДСЭН БАЙГУУЛЛАГУУДЫН ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/Мян.төг/

Байгууллагын нэр	Залруулагдаагүй алдаа, зөрчлийн дүн		Үүнээс: Залруулагдаагүй алдаа, зөрчлийн шийдвэрлэлт					
			Тогтоосон төлбөрийн акт		Өгсөн албан шаардлага		Өгсөн зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
ЗДТГ-ЗА	4	87,676.80	1	1,250.00	3	86,426.80		
ИТХ-ЗА	3	29,881.1			3	29,881.10		
ИТХ	1	2,620.10			1	2,620.10		
ОНХС-ЗА	3	116,094.70			3	116,094.70		
ХХС-ЗА	1	50,345.60			1	50,345.60		
ЭМТ/тогтмол зардал/	1	14,000.00			1	14,000.00		
Нийт	13	270,737.2	1	1,250.00	12	299,368.30		